

**МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2026 оны 07 сарын 27

№ 26/ТУЗ/36

Улаанбаатар хот

**“Компанийн хувьцааг эргүүлэн худалдан авч,
халааслах тухай”**

Компанийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1, 49.4 дэх заалт, 55 дугаар зүйлийн 55.2 дахь заалт, 76 дугаар зүйлийн 76.1.7 дахь заалт, Монложистикс Холдинг ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.14.13 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.7, 11.8 дахь заалт болон Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2026 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн ээлжит хурлын санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Монложистикс Холдинг” ХК-ийн хувьцааг энэхүү тогтоолын Хавсралт №1-д заасан нөхцөл, журмын дагуу Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтээс эргүүлэн худалдан авч, халааслахаар шийдвэрлэсүгэй.
2. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хувьцаа эргүүлэн худалдан авах ажлыг зохион байгуулж, Төлөөлөн Удирдах Зөвлөлийг холбогдох мэдээллээр хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Г.Хишигбат/-д үүрэг болгосугай.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА**



Л.ГАНЗОРИГТ

“Монложистикс Холдинг” ХК-ийн Төлөөлөн
Удирдах Зөвлөлийн 2026 оны 07 сарын 27 -ны өдрийн
№ 26/ТУЗ/36 тогтоолын Хавсралт №1

КОМПАНИЙН ХУВЬЦААГ ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАН АВЧ, ХАЛААСЛАХ НӨХЦӨЛ

1	Эргүүлэн худалдаж авах хувьцааны нийт тоо, ширхэг	7,140,000 (долоон сая нэг зуун дөчин мянга) ширхэгээс ихгүй.
2	Эргүүлэн худалдан авах захиалгын дээд үнэ	210 (хоёр зуун арав) төгрөг/хувьцаа
3	Эргүүлэн худалдан авах үйл ажиллагаа үргэлжлэх хугацаа	2026.09.01- 2027.12.31-ний өдрийг дуустал
5	Эргүүлэн худалдаж авах хувьцааны үнийн дүнгийн дээд хэмжээ	1,500,000,000 (нэг тэрбум таван зуун сая) төгрөг хүртэл үнийн дүнгээр эргүүлэн худалдан авах ажиллагааг хэрэгжүүлнэ.